



**“ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН” ТӨВ ТӨААТҮГ
“ХУБИЛАЙ ХААН СААН” НАРЫН
ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Хубилай хаан сан нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн хүрээнд дэд бүтцийн болон бусад Түншлэлийн төслүүдийг хэрэгжүүлэх сонирхлоо илэрхийлж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвтэй мэдээлэл солилцох, хамтран ажиллахаар Харилцан ойлголцлын санамж бичгийг доорх нөхцөлөөр байгуулав.

1. “Хубилай хаан сан” гийн сонирхож буй нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээ, аялал жуулчлалын салбарын төслүүдийн холбоотой мэдээллээр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв нь ханган хамтран ажиллахаар.
2. Хубилай хаан сан нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд Түншлэлийн төслийн бүрэн шинжилгээ хийхэд шаардлагатай материалыг боловсруулахад Төр хувийн хэвшлийн түншлэлийн төв нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллахаар.
3. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Аялал жуулчлалын гол зам дагуу амрах өртөө, түр буудаллах үйлчилгээний цогцолбор байгуулах” төсөл нь олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн үр өгөөжтэй байхыг талууд харилцан зөвшөөрөв.
4. Харилцан ойлголцлын санамж бичиг нь Талуудын хооронд хамтын ажиллагааг эхлүүлэх үндэс болох ба санамж бичгийн хүрээнд аль нэг тал нь тодорхой гэрээ байгуулах, ямар нэг үйлчилгээ үзүүлэх эсхүл төлбөр төлөх үүрэг хүлээхгүй.
5. Харилцан ойлголцлын санамж бичгийг 2 (хоёр) хувь үйлдэж талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг даран тал тус бүр нэг хувийг хадгална.

“Төр хувийн хэвшлийн түншлэлийн төв”



“Хубилай хаан” Сан



2025 оны 09 сарын 18 өдөр
Улаанбаатар хот